



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2017 оны 06 сарын 23 өдөр

Дугаар А/203

Мандалговь

Г Хуулийн хэрэгжилтийг хангах тухай Г


Монгол Улсын Сонгуулийн тухай хуулийн 96 дугаар зүйлийн 96.1, 96.1.1 дэх заалтуудыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Монгол Улсын Ерөнхийлөгчийн ээлжит сонгууль явагдаж байгаатай холбогдуулан 2017 оны 06 дугаар сарын 25-27-ны өдрүүдэд архи согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэхийг хориглосугай.

Хоёр. Захирамжийн хэрэгжилтийг ханган, тухайн өдрүүдэд архи согтууруулах ундаагаар үйлчилж, худалдан борлуулахгүй байхыг нутаг дэвсгэрийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй тусгай зөвшөөрөл бүхий нийт аж ахуйн нэгжийн удирдлагуудад даалгасугай.

Гурав. Сонгуулийн үеэр олон нийтийн хэв журмыг чанд сахиулан, гэмт хэрэг зөрчил гарахаас урьдчилан сэргийлж, ард иргэдийн амгалан тайван, аюулгүй байдлыг хангаж ажиллахыг аймгийн Цагдаагийн газар /Б.Очирдорж/, сумдын Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



О.БАТ-ЭРДЭНЭ

0200639